

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 29 өдөр

Дугаар: 35

Улаанбаатар хот

Ажил хавсран гүйцэтгүүлэх
тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 82 дугаар зүйлийн 82.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.9, 5.11, 5.12-т заасныг заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндсэн ажлынхаа зэрэгцээ “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгэхийг дотоод аудитын ажилтан Батцэнгэлийн Ангарт даалгасугай.
2. Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг хариуцлагатай хэрэгжүүлж ажиллахыг Б.Ангарт үүрэг болгосугай.
3. Б.Ангарт Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг хавсран гүйцэтгэх хугацаанд нь Хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод (журам) хэм хэмжээнд заасны дагуу нэмэгдэл хөлс олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д зөвшөөрсүгэй.
4. Энэ тогтоолыг Б.Ангарт танилцуулахыг Захиргаа, удирдлагын газрын дарга (Э.Ванчинхүү)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ